

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2019-2022 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН СЭДЭВТ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	АГГ-2022/17-ШТА-ГА	Шалгагдсан байгууллага:	Сангийн яам
Аудитын нэр:	Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт, үр дүн		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Аудитын гуравдугаар газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Ахлах аудитор Б.Болормаа, Б.Анхбаатар Аудитор Э.Уянга, Э.Уужимсан Ч.Баярмаа

Хоёр. Аудитын үр дүн:

Аудитын зорилт: “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитыг доорх 2 дэд зорилтын хүрээнд гүйцэтгэн дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдлээ. Үүнд:

1. Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийг зохих хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэх;
2. Холбогдох төрийн байгууллагууд бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газрыг өрийн удирдлагын талаарх чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ: Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын өрийн удирдлагын талаар хэрэгжүүлэх чиг үүргийн хэрэгжилт, Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт, үр дүнгийн тайлал, тайлант хугацааны өрийн байдал, түүнд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөллийн судалгаа, шинжилгээг аудитад хамрууллаа.

БҮЛЭГ 1. ӨРИЙН СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧГИЙГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХӨГЖЛИЙН БОДЛОГОД НИЙЦҮҮЛЭН БОЛОВСРУУЛСАН БАЙНА

Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийг улсын хөгжлийн богино, дунд, урт хугацааны бодлоготой уялдуулан боловсруулжээ

Өрийн удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасныг үндэслэн Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийг боловсруулан УИХ-ын 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 55 дугаар тогтоолоор батлуулжээ.

Дэлхийн банк, ОУВС-ийн өрийн дунд хугацааны стратеги боловсруулах аргачлалыг ашиглан, Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийг боловсруулсан байна.

Тус стратегийн баримт бичигт дараах онцлог арга хэмжээнүүдийг тусгажээ. Үүнд:

- Төсвийн сахилга бат, санхүү мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах бодлогыг тууштай үргэлжлүүлэх замаар төсвийн алдагдал болон шинээр зээллэг үүсгэх хэрэгцээг бууруулна;
- Гадаад зах зээлийн нөхцөл байдал, зардал, эрсдэлийн судалгааг тогтмол хийж, гадаад үнэт цаасны төлбөрийг мөнгөн хөрөнгийн хуримтлалаас боломжит хэмжээгээр төлж барагдуулах, хугацаанаас нь өмнө худалдан авах, дахин санхүүжүүлэх арга хэмжээг авна;
- Дахин санхүүжилт хийхээс өөрөөр арилжааны нөхцөлтэй гадаад үнэт цаас гаргахаас татгалзана. Өрийн дахин санхүүжилтэд урт хугацаанд жигд төлөгдөх эх үүсвэрийг ашиглахыг эрмэлзэнэ;
- Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаанд орчин үеийн дэвшилтэт технологийг ашигласан систем нэвтрүүлнэ;
- Олон улсын санхүүгийн байгууллагуудаас санал болгож байгаа болзошгүй эрсдэлээс сэргийлэх зээлийн шугамыг ашиглах механизмыг нэвтрүүлнэ;
- Барих-шилжүүлэх төрлийн концессын гэрээ байгуулах, өрийн бичиг бичих зэрэг өрийн хэрэгслээр өр үүсгэхгүй байх бодлогыг баримтална.

Өрийн удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу орон тооны бус Өрийн удирдлагын зөвлөл дараах асуудлаар зөвлөмж гаргах чиг үүргээ хэрэгжүүлсэн эсэхийг баримтжуулсан нотлох баримт байхгүй байна. Үүнд:

- Макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал, мөнгөний бодлого, Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээнд нийцүүлэн өрийн удирдлагын бодлого, стратегийн төлөвийг тодорхойлох;
- Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийг боловсруулах;
- Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегид заасан зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох;
- Өрийн тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтүүдийн гүйцэтгэл гаргах;
- Засгийн газрын өрийн зохицуулалтын үйл ажиллагаа явуулах;
- Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, өрийн зохицуулалтын үйл ажиллагааг дүгнэх.

Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг бүрэн тайлагнаагүй байна

Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичигт тусгасан 5 зорилтыг хэрэгжүүлэх дараах 10 арга замын хэрэгжилтийг бүрэн тайлагнаагүй байна. Тухайлбал:

- Төсвийн сахилга бат, санхүү мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах бодлогыг тууштай үргэлжлүүлэх замаар төсвийн алдагдал болон шинээр зээллэг үүсгэх хэрэгцээг бууруулна;
- Өрийн удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан өрийн багцын оновчтой бүтцийг бий болгох зохицуулалтын арга хэмжээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр шуурхай, бие даан авч хэрэгжүүлнэ;
- Дахин санхүүжилт хийхээс өөрөөр арилжааны нөхцөлтэй гадаад үнэт цаас гаргахаас татгалзаж, өрийн дахин санхүүжилтэд урт хугацаанд жигд төлөгдөх эх үүсвэр ашиглахыг эрмэлзэнэ;
- Засгийн газрын өрийн багц дахь хувьсах хүүтэй гадаад зээлийг зардал, эрсдэлийн судалгаагаар ашигтай нөхцөлд тогтмол хүүтэй зээлд шилжүүлнэ;
- Шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн саналд дүн, шинжилгээ хийх механизмыг бий болгож, эдийн засаг, нийгэмд зайлшгүй шаардлагатай төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлнэ;
- Засгийн газрын дотоод үнэт цаасны үр ашиг, эрсдэлийн талаарх иргэн, аж ахуйн нэгжид чиглэсэн мэдлэг дээшлүүлэх арга хэмжээг авна;
- Засгийн газрын өрийн баталгаа, батлан даалттай төслүүдэд эрсдэлийн үнэлгээ тогтмол хийх тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлнэ;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах баталгаа гаргах, концессын төлбөрийг төлөх баталгааны захидал олгох зэргээр шууд бусаар болзошгүй өр, төлбөр үүсгэж байгааг хянах, оновчтой удирдах эрх зүйн орчныг бүрдүүлнэ;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8.6-д заасан Засгийн газрын өрийн баталгааны хэмжээг 2018 оноос нэмэгдүүлэхгүй байх бодлогыг баримтална;
- Олон улсын санхүүгийн байгууллагуудаас санал болгож байгаа болзошгүй эрсдэлээс сэргийлэх, зээлийн шугамыг ашиглах механизмыг нэвтрүүлнэ.

Улсын нийт гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 33.2 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд 37.0 хувийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 25.6 хувийг Засгийн газрын өр, 24.8 хувийг бусад салбарын өр, 7.7 хувийг Төв банкны өр, 5.0 хувийг хадгаламжийн байгууллагын өр тус тус эзэлж байна.

Хүснэгт 1. Улсын нийт гадаад өрийн статистик (сая ам.доллар)

Салбарын ангилал	2018 он	2019 он	2020 он	2021 он УГ
Засгийн газар	7,184.2	7,806.2	8,653.8	8,482.6
Төв банк	2,030.2	1,984.7	2,221.0	2,561.8
Хадгаламжийн байгууллага /Төв банкнаас бусад/	2,230.4	2,138.0	1,650.9	1,651.3
Бусад салбарууд	8,041.9	8,407.2	8,430.2	8,222.0
Компани хоорондын зээллэг, шууд хөрөнгө оруулалт	9,228.2	10,366.2	11,405.9	12,272.8
Нийт гадаад өр	28,714.9	30,702.3	32,361.8	33,190.5

Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын нийт гадаад өрийн 2021 оны үлдэгдэл 2018 оноос 4.5 тэрбум ам.доллараар нэмэгдэж, 33.2 тэрбум болсон нь манай улсын гадаад валютын нөөцөөс 7.5 дахин их байна.

Засгийн газрын өрийн өнөөгийн байдал

Засгийн газрын гадаад өрийн үлдэгдлийн хэмжээ 2021 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 8.5 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 0.2 тэрбум ам.доллараар буурч, 2018 оноос 1.3 тэрбум ам.доллараар нэмэгдсэн байна. Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 27,221.8 тэрбум төгрөгт хүрч, 2018 оноос 4,854.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа 50.8 хувь болж, 2018 оноос 7.7 пунктээр буурсан байна.

Хүснэгт 2. Засгийн газрын өрийн бүтэц (тэрбум төгрөг)

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2018 он	2019 он	2020 он	2021 он УГ
Засгийн газрын дотоод өр	1,564.7	1,399.6	1,136.6	920.6
Засгийн газрын гадаад өр	18,865.6	20,728.1	24,851.4	24,693.3
Бусад өр төлбөр	1,936.7	2,072.0	1,910.6	1,590.7
Орон нутгийн зээллэг				17.2
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР	22,367.0	24,199.7	27,898.6	27,221.8

Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 24,693.3 тэрбум төгрөгт хүрч, 2018 оноос 5,827.7 тэрбум төгрөгөөр өсжээ.

Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор авсан зээлүүд гадаад валютаар илэрхийлэгдсэн, Засгийн газрын дотоод үнэт цаас арилжаалаагүй тул гадаад валютаар илэрхийлсэн өрийн баталгаа болон барих-шилжүүлэх концессоос бусад Засгийн газрын нийт өрд эзлэх хувь 2018 онд 92.3 хувь байсан бол 2019 онд 93.7, 2020 онд 95.6, 2021 онд 96.3 хувьд хүрч өссөн байна.

Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 24,693.3 тэрбум төгрөгт хүрч, 2018 оноос 5,827.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд 41.5 хувь нь ханшийн өөрчлөлтийн нөлөөллөөр, 58.5 хувь нь бодит өсөлтөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын нийт өрийн 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 60.7 хувийг гадаад зээл, 30.0 хувийг гадаад үнэт цаас буюу гадаад валютаар илэрхийлэгдэх өр эзэлж, гадаад өрийн өсөлтөд нөлөөлж буй ханшийн нөлөөлөл 41.5 хувь байгаагаас харахад манай улс валютын ханшийн эрсдэлд өртөмтгий байгааг илэрхийлэх бөгөөд ойрын жилүүдэд ам.долларын ханшаас хамаарсан өрийн хэмжээ нэмэгдэх эрсдэлтэйг харуулж байна.

Өрийн удирдлагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өр төлбөрийг Засгийн газрын өрийн дүнд оруулж тайлагнахгүй байна.

Засгийн газрын өрийн харьцааны жишиг шалгуур үзүүлэлт байхгүй, нэгдсэн төсвийг алдагдалтай баталж байгаагаас Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан өрийн хязгаарыг тодотгон өрийн хэмжээг нэмэгдүүлж байна

Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцааг 2020 онд 54.3, 2021 онд 50.0 хувиас хэтрүүлэхгүй гэж төсөөлсөн боловч гүйцэтгэлээр 2020 онд 7.2, 2021 онд 0.8 пунктээр тус тус хэтэрсэн байна.

Засгийн газрын өрийн босго хэмжээг нэмэгдүүлэх замаар шинээр нэмж зээл авах нь Засгийн газрын өрийн дарамт, төсвийн дарамтыг нэмэгдүүлэх сөрөг нөлөөллийг үзүүлэх эрсдэлтэй байна.

Засгийн газрын өр/ДНБ-ий харьцаа үзүүлэлтийг 2019 онд 68.3, 2020 онд 65.8, 2021 онд 61.1 хувиас хэтрүүлэхгүй гэж төсөөлсөн боловч гүйцэтгэлээр 2020 онд 8.7, 2021 онд 2.2 пунктээр тус тус хэтэрсэн байна.

Олон улсын валютын сангаас Засгийн газрын өр/ДНБ-ий харьцаа үзүүлэлтийн сэрэмжлэх түвшнийг 50.0 хувь гэж зөвлөсөн бөгөөд манай улсын хувьд 2019-2021 онд тус харьцаа 63-75 хувьтай байгаа нь сэрэмжлэх түвшнээс давсан байна.

Олон улсын валютын сангаас нийт санхүүжилтийн хэрэгцээ/ДНБ-ий харьцаа үзүүлэлтийн сэрэмжлэх түвшнийг 10 хувь гэж зөвлөсөн бөгөөд 2020-2021 онд энэ үзүүлэлтийг хангаагүй байна.

Засгийн газрын өр (ӨҮЦ)/ДНБ харьцаа 2015-2021 онд 51.0-79.0 хувь байгаа нь ОУВС-ийн зөвлөсөн харьцаанаас өндөр байна. Энэ нь Засгийн газрын өрийн түвшин өндөр, нөгөө талаас дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ бага байгаатай холбоотой.

Засгийн газрын өр (ӨҮЦ)/Экспортын харьцаа 2016 оноос хойш буурсан буюу ОУВС-аас зөвлөсөн хэмжээнээс доогуур байна. Энэ нь Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангаж байгааг илтгэх бөгөөд 2021 оны хувьд Засгийн газрын өрийг /ӨҮЦ/ улсын 1 жилийн экспортын орлогын 83.0 хувиар төлөх боломжтойг харуулж байна.

Засгийн газрын өр (ӨҮЦ) /Засгийн газрын орлогын харьцаа 2015-2020 онд 285-489 хувьтай байсан нь ОУВС-аас зөвлөсөн 250.0 хувиас өндөр байна. Энэ нь Засгийн газрын өр өндөр, төсвийн орлого бага байгааг харуулж байгаа бөгөөд улсын төсөвт өрийн дарамт үзүүлж болзошгүй юм. Харин 2021 онд 243.0 хувьд хүрч зохистой харьцаанд орж, өрийн тогтвортой байдлын шалгуурыг хангасан байна.

Засгийн газрын өрийн үйлчилгээ/Экспортын харьцаа 2019 онд 19.0 хувь байснаас бусад жилд 25.0-124.0 хувь буюу ОУВС-ийн зөвлөсөн 20.0 хувиас өндөр байсан байна. Энэ нь нийт өрийн үйлчилгээний төлбөр өндөр бөгөөд 1 жилийн экспортын орлогын 25.0-124.0 хувьтай тэнцэж байгаа нь гадаад валютын гарах урсгалыг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлж, гадаад валютын нөөцийг бууруулж байгааг илэрхийлж байна.

Засгийн газрын өрийн үйлчилгээ/Засгийн газрын орлого харьцаа үзүүлэлт 2019-2021 онд 19.0-28.0 хувь байгаа нь ОУВС-аас зөвлөсөн 30.0 хувиас доогуур байна. Энэ нь Засгийн газрын өрийн тогтвортой байдлын шалгуурыг хангасан бөгөөд өрийн үйлчилгээний төлбөр улсын төсөвт бага дарамт үзүүлсэн.

Олон Улсын валютын сангаас зөвлөсөн Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангах 5 үзүүлэлтээс манай улс 2 үзүүлэлтийг хангаж, 3 үзүүлэлтийг хангахгүй байгаа нь манай улсын өрийн тогтвортой байдал бүрэн хангагдаагүй гэж үзэхээр байна.

Засгийн газрын өрийн тогтвортой байдлын 2 үзүүлэлтийг хангасан нь ам.долларын ханш 2018-2021 онуудад харьцангуй тогтвортой байсантай холбоотой бөгөөд цаашид ханшийн өөрчлөлтийн нөлөөллөөр хангагдахгүй болох эрсдэлтэй.

Цаашид Засгийн газрын гадаад өр өндөр, эдийн засгийн өсөлт буурах, төгрөгийн ханш сулрах төлөвтэй байгаа энэ үед богино хугацааны дахин санхүүжилт хийх арга хэмжээг авч болох боловч хугацаа явах тусам өрийн дарамт нэмэгдэж болзошгүй тохиолдолд илүү урт хугацааны эдийн засгийн хөгжлийн цогц, уялдаатай бодлогыг Засгийн газраас хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн хугацаанд өрийн үйлчилгээний зардалд нийт 10,183.4 тэрбум төгрөг зарцуулснаас үндсэн төлбөрт 7,431.5 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 2,751.9 тэрбум төгрөгийг тус тус төлсөн бөгөөд 2019-2021 онд Засгийн газрын дотоод үнэт цаас арилжаалаагүй, хөнгөлөлттэй зээлээр төсвийн алдагдлыг нөхөх, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх бодлогыг баримталсан байна.

Засгийн газрын 2012-2021 онд үүссэн нийт өрийг эргэн төлөх төсөөллөөс харахад 2022-2024 онд Засгийн газрын гадаад зээлийн эргэн төлөлт хамгийн өндөр байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээнд эзлэх нийт төлбөрийн хэмжээ 2022 онд 13.5 хувь, 2023 онд 15.9 хувь, 2024 онд 9.9 хувь болж, хүлээгдэж буй эргэн төлөлт нь улсын төсөвт ачаалал үзүүлэхээр байна.

Засгийн газрын гадаад зээлийн эргэн төлөлтийн тооцооллоос харахад зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр жилээс жилд нэмэгдэхээр байна.

Засгийн газрын 2019-2021 онд авсан нийт гадаад зээлийн 41.7 хувийг төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд зарцуулжээ

Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн зорилт 2-т “Гадаад зээллэгээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд зардал, үр өгөөжийн тооцооллыг хийж, зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх зарчмыг баримтлан тэдгээрийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулна” гэж тодорхойлж, түүнийг дараах арга замаар хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн эдийн засаг, нийгмийн ач холбогдол, зардал үр нөлөөг үнэлэх, эрэмбэлэх арга хэмжээг авна;
- Төсвийн алдагдлыг бууруулж, өрийн хэрэгслийг хязгаарлах замаар шинээр өр үүсгэх шаардлагыг багасгана;
- Шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн саналд дүн, шинжилгээ хийх механизмыг бий болгож, эдийн засаг, нийгэмд зайлшгүй шаардлагатай төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлнэ.

Хандивлагч орон, олон улсын байгууллагаас 2019 онд 1,638.6 тэрбум, 2020 онд 3,368.4 тэрбум, 2021 онд 1,391.4 тэрбум, нийт 6,398.4 тэрбум төгрөгийн гадаад зээл авч ашигласан бөгөөд 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр гадаад зээлийн үлдэгдэл 16,517.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийг 2019-2021 онд алдагдалтай баталсан бөгөөд Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д заасныг үндэслэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар 2019 онд 408.1 тэрбум, 2020 онд 1,978.1 тэрбум, 2021 онд 285.0 тэрбум, нийт 2,671.2 тэрбум төгрөгийн гадаад зээлийг хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан байна.

Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар авсан гадаад зээлийн үлдэгдэл 2019 онд 3,088.1 тэрбум, 2020 онд 5,223.6 тэрбум, 2021 онд 5,551.6 тэрбум төгрөг болсон бөгөөд энэ нь 2019-2021 онд ашигласан нийт гадаад зээлийн 41.7 хувийг эзэлж байна.

Төсвийн зарлагыг нэмэгдүүлж, нэгдсэн төсвийг алдагдалтай баталж байгаа нь гадаад зээлийн өр нэмэгдэх нэг шалтгаан болж, улмаар өрийн үйлчилгээний зардал өсөх, ханшийн эрсдэл үүсэх нөхцөл бий болж байна.

Засгийн газар ОУВС-тай 3 жилийн хугацаанд хамтран хэрэгжүүлсэн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн алдагдлыг бууруулах зорилгоор 2017 онд 606.0 сая ам.доллар, 2018 онд 190.0 сая ам.доллар, 2019 онд 150.0 сая ам.доллар, нийт 946.0 сая ам.доллар буюу 2,361.2 тэрбум төгрөгийн нэн хөнгөлөлттэй зээлийг авчээ.

Засгийн газрын нийт өрийн үлдэгдлийн 60.7 хувийг урт хугацаатай хөнгөлөлттэй нөхцөлтэй гадаад зээл эзэлж байгаа нь ханшийн эрсдэлийг нэмэгдүүлэхээр байна

Засгийн газрын нийт өрийн 60.7 хувийг гадаад зээл эзэлж, 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 16,517.7 тэрбум төгрөгт хүрч, 2018 оноос 5,316.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд 34.7 хувь нь ханшийн өөрчлөлтөөр, 65.3 хувь нь бодит өсөлтөөр нэмэгдсэн байна.

Өрийн удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-т Монгол банкны хэрэгжүүлэх чиг үүргийг заасан боловч тус газар 2019-2021 онд Засгийн газрын зээллэгийн хэмжээ мөнгөний болон валютын зах зээлд нөлөөлөх эсэхэд дүгнэлт гаргаагүй, санал, зөвлөмж хүргүүлж

Гадаад зээлээр шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг үнэлэх, зардал, үр нөлөөгөөр эрэмбэлээгүйгээс хэрэгжилт удаашрах нөхцөл бүрдэж байна

Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.4, 18.5.7-д заасан шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлах ёстой боловч хуулийн шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг баталснаас шалтгаалан гадаад зээлийн хөрөнгийг ашиглаж эхлэхдээ тухайн төсөл, арга хэмжээний зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээг хийж, баталгаажуулах зэргээр цаг хугацаа алдсанаас төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах нөхцөл бүрдсэн байна.

Засгийн газрын шинээр авах зээл нь Өрийн удирдлагын тухай хуулийн 18.5.3, 18.5.4, 18.5.7-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд Сангийн яам санал, дүгнэлт гаргахаар тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.6-д заасан боловч хэрэгжүүлээгүй байна.

Гадаад зээллэгээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдэд эдийн засаг болон нийгмийн ач холбогдлыг тооцоолдоггүй, зардал үр нөлөөгөөр эрэмбэлэх арга хэмжээг авдаггүйгээс төсвийн зардлын хязгаараас давсан зээллэг, нөгөө талаас үр дүнгүй зээллэг хийх эрсдэлтэй, мөн стратегийн баримт бичгийн зорилт хангалттай хэрэгжих нөхцөл бүрдэхгүй байна.

Гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төслийн баримт бичгийг ямар түвшинд боловсруулсан байх, техник эдийн засгийн үндэслэл, төслийн баримт бичгийн үнэлгээг аль үе шатанд хийх зэрэг аргачлалыг хууль, журамд тодорхой тусгаагүй, эрх зүйн зохицуулалтгүй байна.

Төсөл, арга хэмжээний нийгэм, эдийн засагт зайлшгүй шаардлагатай эсэхийг үнэлэх арга аргачлал байхгүйгээс тухайн төслийг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэхийг тодорхойлдоггүй байна.

Гадаад валютын албан нөөц бага, улсын төсвийг алдагдалтай баталдаг зэргээс шалтгаалан Монгол Улсын зээлжих зэрэглэл сайжраагүй байна

Сангийн яам Standard and Poor's агентлагтай 1999 оноос, Fitch болон Moodys агентлагтай 2005 оноос хойш Монгол Улсын зээлжих зэрэглэлийг тогтоох чиглэлээр хамтран ажиллаж ирсэн байна.

Монгол Улсын олон улсын зээлжих зэрэглэл 2018-2021 онд өөрчлөгдөөгүй байгаа нь манай улсын эдийн засаг, нийгмийн байдал сайжраагүй болохыг илэрхийлэх бөгөөд 2018 оноос хойш “В” буюу хөрөнгө оруулалт хийхэд эрсдэлтэй улс гэж үнэлжээ.

Засгийн газрын гадаад үнэт цаасыг дахин санхүүжүүлж, тухайн жилд төсвийн алдагдал нэмэгдэхээс сэргийлсэн боловч урт хугацаанд эргэн төлөх өрийн хэмжээ өндөр хэвээр байна

Засгийн газар Чингис бондын 863.1 сая, Мазаалай бондын 367.4 сая, Гэрэгэ бондын 266.9 сая ам.долларын өрийг хугацаанд нь төлөхгүйгээр Номад, Сентури бондыг гарган өрийн зохицуулалтыг хэрэгжүүлсэнээр Монгол Улс Номад бондын хүүд 2020 оноос 2026 он хүртэл 169.1 сая, Сентури-1, Сентури-2 бондын хүүд 2021-2031 он хүртэл 380.5 сая, нийт 549.6 сая ам.доллар, үндсэн төлбөрт 2026 онд 600.0 сая, 2027 онд 500.0 сая, 2031 онд 500.0 сая, нийт 1,600.0 сая ам.долларыг төлөхөөр байна.

Засгийн газрын гадаад үнэт цаасны 2021 оны үлдэгдэл урьдчилсан гүйцэтгэлээр 8,175.6 тэрбум төгрөгт хүрч, Засгийн газрын өрийн 30.0 хувийг эзэлж байна.

Сангийн яам гадаад үнэт цаасны дахин санхүүжилтийн арга хэмжээг авч өрийн зохицуулалт хийсэн нь тайлант хугацаанд төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх, гадаад валютын албан нөөцийг бууруулахаас сэргийлж, өрийн эргэн төлөх хугацааг хойшлуулсан боловч дунд, урт хугацаанд төлөх үндсэн болон хүүгийн төлбөрийн хэмжээ төсөвт ачаалал үзүүлэхээр байна.

Гадаад үнэт цаасны үлдэгдэл 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 8,175.6 тэрбум төгрөг болж, 2018 оноос 511.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд ханшийн нөлөөлөл 115.6 хувиар нөлөөлсөн байна. Гадаад валютын ханш өөрчлөлтөөс хамааран цаашид Засгийн газрын өрийн хэмжээ нэмэгдэх эрсдэл өндөр байна.

Засгийн газар 2020 оны 10 дугаар сарын 06-ны өдөр 600.0 сая ам.долларын нэрлэсэн үнэтэй Номад бондыг шинээр гарган дараах үнэт цаасыг дахин санхүүжүүлсэн байна. Үүнд:

- 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр хугацаа дуусах Чингис бондын 200.8 сая ам.доллар,
- 2021 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр хугацаа дуусах Мазаалай бондын 367.4 сая ам.доллар.

Мөн 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдөр тус бүр нь 500.0 сая ам.долларын нэрлэсэн үнэтэй Сентури 1, 2 бондыг шинээр гаргаж, гадаад үнэт цаасыг дахин санхүүжүүлсэн байна. Үүнд:

- 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр хугацаа дуусах Чингис бондын 662.4 сая ам.доллар,
- 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр хугацаа дуусах Гэрэгэ бондын 266.9 сая ам.доллар.

Бондын дахин санхүүжилтийн өртөг, өнөөгийн үнэ цэнийг тооцоолоход хорогдуулалтын хувь чухал бөгөөд ижил эрсдэлтэй улсуудын Засгийн газрын бондын хүүгийн түвшнээр тогтоодог байна.

Чингис бондын 200.8 сая ам.долларын үндсэн болон хүүгийн төлбөрийн гарах мөнгөн урсгалын 2020 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн дүн 191.4 сая ам.доллар, Номад бондын 211.7 сая ам.долларын үндсэн төлбөр, хүүгийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнэ нь 189.4 сая ам.доллар бөгөөд тэдгээр бондын мөнгөн урсгалын хэмнэлт 2.0 сая ам.доллар болж байна.

Мазаалай бондын 367.4 сая ам.долларын үндсэн болон хүүгийн төлбөрийн гарах мөнгөн урсгалын 2020 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн дүн 373.4 сая ам.доллар, Мазаалай бондын 367.4 сая ам.долларын үндсэн төлбөрт хамаарах Номад бондын 388.3 сая ам.долларын үндсэн болон хүүгийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн дүн 347.3 сая ам.доллар бөгөөд тэдгээр бондын мөнгөн урсгалын хэмнэлт 26.1 сая ам.доллар байна.

Өрийн удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.10-т заасны дагуу Засгийн газрын 2021 оны 65 дугаар тогтоолоор “Засгийн газрын гадаад үнэт цаасыг гаргах, арилжаалах журам”-ыг баталж, олон улсын

зах зээлд Засгийн газрын гадаад үнэт цаас гаргах, арилжаалахтай холбоотой бэлтгэх ажлыг хангах, үйлчилгээ үзүүлэх талуудыг сонгон шалгаруулах үйл ажиллагаа, арилжааг зохион байгуулах, бүртгэх, тайлагнах, хөрөнгө оруулагчидтай харилцах харилцаа, арилжаалах үйл явцыг ил тод зохион байгуулах нөхцөл бүрдсэн байна.

Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Номад бондоор дахин санхүүжүүлсэн Чингис бондын дахин санхүүжилтийн зардлын цэвэр өнөөгийн үнэ цэнэ сөрөг 8.9 сая ам.доллар, Мазаалай бондын дахин санхүүжилтийн зардлын цэвэр өнөөгийн үнэ цэнэ эерэг 5.2 сая ам.доллар, нийт сөрөг 3.6 сая ам.доллар гарч байна. Чингис бондыг Сентури 1, 2 бондоор дахин санхүүжүүлсэнтэй холбоотой гарах мөнгөн урсгалын цэвэр өнөөгийн үнэ цэнээрх хэмнэлт 120,360,389 ам.доллар, Гэрэгэ бондыг Сентури 1,2 бондоор дахин санхүүжүүлсэнтэй холбоотой гарах мөнгөн урсгалын цэвэр өнөөгийн үнэ цэнээрх хэмнэлт нь 48,171,327 ам.доллар болж байна. Засгийн газар 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Чингис болон Гэрэгэ бондыг дахин санхүүжүүлсэн зардлын цэвэр өнөөгийн үнэ цэнэ нь тус бүр эерэг 70.7 сая болон 23.5 сая, нийт цэвэр өнөөгийн үнэ цэнэ эерэг 94.2 сая ам.доллар болж байна.

Мазаалай, Чингис бондыг дахин санхүүжүүлээгүй 2021 онд 600.0 сая ам.доллар, 2022 онд 1.0 тэрбум ам.долларын үндсэн төлбөрийг төлсөн тохиолдолд 2021 онд улсын төсвийн алдагдал 11.1 хувьд хүрч, гадаад валютын албан нөөц 600.0 сая ам.доллороор буурах байжээ. Чингис болон Мазаалай бондыг дахин санхүүжүүлсэн зардлын цэвэр өнөөгийн үнэ цэнэ -3.6 сая ам.доллар буюу сөрөг байгаа боловч Номад бондыг гаргасан нь 2021 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр Мазаалай бондын үндсэн төлбөр төлөх үед улсын төсөвт үзүүлэх ачаалал, төсвийн алдагдлыг 4.0 хувиар буурах, гадаад валютын албан нөөцийг 600.0 сая ам.доллороор багасахаас сэргийлсэн байна.

Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэлтэй байгууллагуудын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх зохицуулалт байхгүйгээс болзошгүй өр төлбөр бий болох эрсдэлтэй байна

Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2018 онд 1,130.7 тэрбум төгрөг байсан бол 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 876.5 тэрбум төгрөг болж, 2018 оноос 254.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл

№	Баталгаа гаргуулагч	Баталгаа гаргасан сая нэгж	Баталгаа гаргасан огноо	Хугацаа	2018 он (тэрбум төгрөг)	2019 он (тэрбум төгрөг)	2020 он (тэрбум төгрөг)	2021 он	
								тэрбум төгрөг	сая ам.доллар
1	МИАТ ТӨХК /зээл/	77.5 /USD/	2013.12.24	10 жил	91.6	72.5	52.4	29.1	10.2
2	МИАТ ТӨХК /зээл/	24.0 /USD/	2013.12.24	10 жил	15.8	7.0	0.0	0.0	
3	Хөгжлийн банк /үнэт цаас/	30,000.0 /JPY/	2014.01.06	10 жил	718.2	751.2	827.4	744.0	261.2
4	Хөгжлийн банк /зээл/	162.0 /USD/	2014.09.05	8 жил	285.4	221.4	153.9	76.9	27.0
5	Эрдэнэс Монгол /зээл/	35.0 /USD/	2016.04.01	15 жил	19.7	24.2	26.7	26.5	9.3
Нийт дүн					1,130.7	1,076.3	1,060.4	876.5	307.7

Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газраас 2016 оноос хойш шинээр өрийн баталгаа, батлан даалт гаргаагүй бөгөөд Засгийн газрын нийт өрд эзлэх өрийн баталгааны үлдэгдэл 2018 онд 5.1 хувь байсан бол эргэн төлөлт хийснээр 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 3.2 хувь болж буурсан байна. Сангийн яам 2016 онд Эрдэнэс Монгол ХХК-ийн 35.0 сая ам.долларын төсөл, арга хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийхгүйгээр Засгийн газрын өрийн баталгаа гаргасан гаргасан нь Өрийн удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-т “Засгийн газрын ...өрийн баталгаа гаргах төсөл, арга хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Засгийн газрын өрийн баталгаа гаргуулсан хуулийн этгээд төлбөрийн чадваргүй болж зээл болон үнэт цаасны төлбөрийн үүргээ биелүүлэх боломжгүй эрсдэл үүссэн тохиолдолд хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх зохицуулалтыг журамд тусгаагүй байна.

Иймд Засгийн газрын өрийн баталгаа гаргуулсан 3 байгууллагын 876.5 тэрбум төгрөгийн үлдэгдлийг тус байгууллагууд төлбөрийн чадваргүй болж, төлж чадахааргүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тэдгээрийн өр төлбөрийг Засгийн газар буюу улсын төсвөөс төлөх эрсдэлтэй юм.

Засгийн газрын баталгаа гаргасан зээлийн эргэн төлөлтийн хуваарийг харахад хамгийн их төлөлт 2023 онд буюу Хөгжлийн банкны 30.0 тэрбум иений өр байна. Хөгжлийн банкнаас зээл авсан зээлдэгчид төлбөрөө хугацаанд нь төлөхгүй төлбөрийн чадварын эрсдэлд орсон тохиолдолд болзошгүй өр төлбөр бий болох эрсдэлтэй байна.

Өрийн удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.7-д “Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, концессын гэрээний дагуу улирал бүр гарсан ашиглалтыг үндэслэж Засгийн газрын өрд

бүртгэнэ” гэж заасны дагуу Сангийн яам концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутгийн Засаг захиргааны байгууллагуудаас улирал бүр ашиглалт, гүйцэтгэлийн мэдээллийг авч, нэгтгэн бүртгэсэн байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан өрийн баталгааны хэмжээг нэмэгдүүлэхгүй байх, “барих-шилжүүлэх” төрлийн концессын гэрээ, өрийн бичгээр болзошгүй өр төлбөр үүсгэхгүй байх бодлогыг баримталж, шинээр концессын гэрээ байгуулаагүй бөгөөд 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр улсын төсвөөс эргэн төлөх 8 гэрээний 713.8 тэрбум төгрөг, орон нутгийн төсвөөс эргэн төлөх 3 гэрээний 0.4 тэрбум төгрөг, нийт 714.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх концессын үлдэгдэл 2018 оны жилийн эцсийн байдлаар 806.0 тэрбум төгрөг байсан бол 2021 оны эцсийн байдлаар 714.2 тэрбум төгрөгт хүрч, 2018 оноос 91.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Засгийн газрын гадаад бондын богино хугацаанд төлөх төлбөрийн дахин санхүүжилтийг шийдвэрлэж, төсвийн алдагдлыг багасгаж, гадаад валютын албан нөөц болон тухайн жилд хуваарийн дагуу төлөх өрийн эргэн төлөлтөөс улсын төсөвт учруулах дарамтыг бууруулахаас сэргийлсэн боловч урт хугацаанд эргэн төлөх өрийн хэмжээ өндөр хэвээр байна.
- Гадаад валютын албан нөөц бага, улсын төсвийг алдагдалтай баталдаг, гадаадын хөрөнгө оруулалтын орчин таагүй байгаагаас шалтгаалан Монгол Улсын зээлжих зэрэглэл хэвээрээ байна.
- Монголбанк Өрийн удирдлагын тухай хуулиар хүлээсэн Засгийн газрын хийх зээллэгийн хэмжээ Монгол Улсын мөнгөний болон валютын зах зээлд нөлөөлөхүйц байх тохиолдолд тухай бүр холбогдох санал зөвлөмжийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.
- Өрийн удирдлагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргах, түүнийг бүртгэхээс бусад тохиолдолд тухайн хуулийн этгээдийн өр төлбөрийн харилцаанд энэ хууль хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өр төлбөрийг Засгийн газрын өрийн дүнд тайлагнадаггүй байна.
- Засгийн газрын нийт өрийн 90.7 хувийг гадаад өр эзэлж байгаагаас шалтгаалан гадаад валютын ханшийн нөлөөллөөр өрийн хэмжээ нэмэгдсэн байхад ханшийн эрсдэлээс сэргийлэх, удирдах зорилт, арга хэмжээг Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичигт тусгаж, хэрэгжүүлээгүй байна;
- Шинээр гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг үнэлэх, зардал, үр нөлөөгөөр эрэмбэлэх аргачлал байхгүйгээс өр үүсгэж бий болгосон хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зарчим хэрэгжихгүй байна.
- Засгийн газрын гадаад зээлийн 41.7 хувийг 2019-2021 онд улсын төсвийн алдагдлыг нөхөхөд зарцуулсан, Засгийн газрын нийт өрийн үлдэгдлийн 60.7 хувийг урт хугацаатай, хөнгөлөлттэй нөхцөлтэй гадаад зээлийн үлдэгдэл эзэлж байгаа нь цаашид ханшийн эрсдэлийг нэмэгдүүлэхээр байна.
- Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг явуулах зайлшгүй шаардлага үүсэх тохиолдолд бэлэн байдлыг хангаагүй байгаа нь стратегийн баримт бичигт дэвшүүлсэн зорилтдоо хүрэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.
- Олон Улсын санхүүгийн байгууллагаас санал болгосон болзошгүй эрсдэлээс сэргийлэх, зээлийн шугамыг ашиглах механизмыг нэвтрүүлэх арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.
- Сангийн яам Өрийн удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-т заасны дагуу Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх болон өрийн баталгаа гаргах төсөл, арга хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулаагүй байна.
- Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэлтэй байгууллагуудын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх зохицуулалтыг хууль, журамд тусгаагүйгээс болзошгүй өр төлбөр бий болох эрсдэлтэй байна.
- Засгийн газрын өрийн удирдлагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс өрийн удирдлагын тогтолцоо сайжраагүй байна.
- Монгол Улсын Засгийн газрын өрийн харьцааны жишиг шалгуур үзүүлэлт байхгүй, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалтай баталж байгаагаас Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан өрийн хязгаарыг тодотгон өрийн хэмжээг нэмэгдүүлж байна.
- Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн зорилт, хэрэгжүүлэх арга зам, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүйгээс стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг бүрэн тайлагнаагүй байна.
- Өрийн удирдлагын зөвлөл Өрийн удирдлагын тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолоор баталсан “Өрийн удирдлагын зөвлөлийн ажиллах журам”-д заасан өрийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, хэрэгжүүлэхэд зөвлөх чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Монголбанкнд:

- Монголбанк, Засгийн газрын хийх зээллэгийн хэмжээ нь Монгол Улсын мөнгөний болон валютын зах зээлд нөлөөлөхүйц байх тохиолдолд тухай бүр холбогдох санал, зөвлөмжийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх гэж заасан Өрийн удирдлагын тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах.

Сангийн сайдад:

- Улсын төсвийн алдагдлыг бууруулах замаар төлбөр төлөх хугацаа тулсан гадаад үнэт цаасны төлбөрийг хуваарийн дагуу төлж, барагдуулах;
- Олон улсын санхүүгийн байгууллага, зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагатай хамтран ажиллаж, Монгол Улсын зээлжих зэрэглэлийг тогтвортой байлгах, зэрэглэлийг ахиулах, бууруулахгүй байх арга хэмжээг эрчимжүүлэх;
- Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өр төлбөрийг Засгийн газрын өрийн дүнд оруулан тайлагнах асуудлыг судалж, хуульд өөрчлөлт оруулах;
- Гадаад валютын ханшийн эрсдэлээс сэргийлэх, удирдах зорилт, арга хэмжээг Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт тусгаж, хэрэгжүүлэх;
- Өрийн удирдлагын тухай хуулийн 25.9-д заасны дагуу түнш орон, олон улсын байгууллагаас бусад эх үүсвэрээс Засгийн газрын гадаад зээл авах, хэлэлцээр байгуулахтай холбоотой эрх зүйн харилцааг нарийвчлан зохицуулах;
- Шинээр гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг нийгэм, эдийн засагт зайлшгүй шаардлагатай эсэхийг тодорхойлох арга аргачлалыг тодорхойлж, хэрэглээнд нэвтрүүлэх, үр ашигтай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, улсын төсвийн алдагдлыг бууруулах замаар шинээр гадаад өр үүсгэх шаардлагыг багасгах;
- Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг явуулах зайлшгүй шаардлага үүсэх тохиолдолд хугацаа алдахгүй бэлэн байдлыг хангах арга хэмжээг авах;
- Өрийн удирдлагын тухай хууль, журамд заасны дагуу Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх болон өрийн баталгаа гаргах төсөл, арга хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, төрийн аудитын байгууллагаар аудит хийлгэж, дүгнэлт гаргуулж байх;
- Засгийн газрын баталгаа, батлан даалтын өрийн үлдэгдэл бүхий байгууллагын зээллэгийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөх чадвар, төсөвт үүсэж болзошгүй эрсдэлийг судлах, үнэлэх, удирдах асуудлыг хууль, журамд тусган эрсдэлийн үнэлгээг жил бүр, шаардлагатай тохиолдолд тухай бүр хийж байх;
- Сангийн сайдын 2020 оны 188 дугаар тушаалаар баталсан “Өрийн удирдлагын тогтолцооны болон үйл ажиллагааны хөгжлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангаж ажиллах;
- Монгол Улсын онцлогт тохирсон олон улсад ашиглаж байгаа Засгийн газрын өрийн харьцааны жишиг шалгуур үзүүлэлтийг хууль, эрх зүйн баримт бичигт тусган мөрдөж ажиллах;
- Стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу бүрэн тайлагнах;
- Өрийн удирдлагын зөвлөл Өрийн удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолоор баталсан “Өрийн удирдлагын зөвлөлийн ажиллах журам”-д заасан өрийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, хэрэгжүүлэхэд зөвлөх чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах.